

Тогтвортой хөгжлийн тайлан 2024





УДИРТГАЛ

- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Компанийн танилцуулга
- Тайлангийн тухай



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
- БОНЗ-ын тогтолцоо
- Бидний оролцоо



БАЙГАЛЬ ОРЧИН

- Байгаль орчны эрсдэл
- Байгалийн гамшгийн хамгаалалт
- Хариуцлага



НИЙГЭМ

- Хариуцлагатай даатгагч
- Хариуцлагатай ажил олгогч
- Хариуцлагатай хувьцаат компани
- Хариуцлагатай хамтын ажиллагаа



ЗАСАГЛАЛ

- Компанийн засаглал
- Ёс зүй ба комплайнс
- Эрсдэлийн удирдлага
- Мэдээллийн аюулгүй байдал



ХАВСРАЛТ

- БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж
- SASB удирдамж

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Нийт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, даатгуулагч, харилцагч, түншүүд та бүхний амгаланг айлтгая.

Ард даатгал ХК нь үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан даатгалын салбарт анх удаа “Тогтвортой хөгжлийн тайлан 2023”-г гаргаж олон нийт, хөрөнгө оруулагч болон оролцогч талуудад танилцуулж байсан билээ.

Өнгөрөгч 2024 онд ногоон эдийн засагт оруулсан хувь нэмэр болон компанийн үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаарх “Тогтвортой хөгжлийн тайлан-2024” тайланг та бүхэнд танилцуулж буйд баяртай байна.

Бид байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд тулгамдаж буй асуудлуудад хамтдаа гарц, шийдлийг олж, даван туулах хэрэгцээ, шаардлага байгааг онцлон тэмдэглэж, даатгалын салбарт оролцогч талуудад үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зорилгуудыг тусгаж, тайлагнаж байхыг уриалж байна.

Мөн эрчим хүчний хэмнэлт бүхий дэвшилтэт технологи, сэргээгдэх эрчим хүч, усны зарцуулалт бага, усны зохистой хэрэглээ, ногоон дэд бүтэц бүхий аж ахуйн нэгж байгууллага, төслүүдийг эрсдэлээс хамгаалж ажиллах нь тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэгч, ногоон эдийн засгийн хөгжлийг бүрдүүлэгч нь байж чадна гэдэгт итгэж байна.

Ард даатгал компани нь нийгэмд ээлтэй, ногоон ирээдүйг бүтээх хэн бүхнийг үргэлж дэмжин, хамтран ажиллаж, хамтдаа урагш тэмүүлж тогтвортой хөгжлийг бүрдүүлэх энэхүү аяллаа зогсолтгүй үргэлжлүүлэх болно.

ТА БҮХЭНД ТАЛАРХАЖ, ХҮНДЭТГЭСЭН

Н.ЭРДЭНЭТУЛГА
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
АРД ДААТГАЛ ХК



Компанийн танилцуулга

Ард даатгал ХК нь 1994 онд үүсгэн байгуулагдаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2/16 тоот даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч 30 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй анхны хувийн даатгалын байгууллага юм.

2018 онд IPO гарган 9,500 орчим хувьцаа эзэмшигчтэй Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болсон.

Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэгүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй, тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь улсынхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна.



Нийт хөрөнгө

51.1 тэрбум төгрөг

Зах зээлд эзлэх хувь

9.0%

Цэвэр ашиг

2.4 тэрбум төгрөг

Нөхөн төлбөр

19.7 тэрбум төгрөг

Даатгуулагчийн тоо

256,000 гаруй

Хураамжийн орлого

45.2 тэрбум төгрөг

Алсын хараа

Даатгуулагчдын ирээдүйдээ итгэлтэй, амар тайван байдлыг хангасан, тэднийг амжилтад хөтөлсөн даатгалын үйлчилгээ үзүүлэгч, шилдэг даатгалын компани болох.

Эрхэм зорилго

Даатгуулагчийн хэрэгцээнд тохируулсан, ёс зүйг баримталсан, зохистой даатгалын үйлчилгээг бид үзүүлнэ.

Үнэт зүйл

Эрсдэлийг даатгуулж, даатгах нь амжилтын эхлэл юм.

Тайлангийн тухай

Ард даатгал ХК нь НҮБ-аас баталсан байгалийн нөөц бололцоог зохистой ашиглах, тэгш байдлыг хангах, уур амьсгалын тогтвортой байдлыг хангахын төлөөх тогтвортой хөгжлийн 17 зорилгыг дэмжин компанийн бодлого, үйл ажиллагаанд шингээж ажиллахыг зорьдог бөгөөд 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлуудыг энэхүү тайланд тусгалаа.

Тайланд дурдсан санхүүгийн үзүүлэлт, тоон мэдээллийг компанийн 2024 оны жилийн тайлан болон аудитлагдсан тайлангаас харах боломжтой. Тайлантай холбоотой асуулт, санал хүсэлт, сэтгэгдлийг info@arddaatgal.mn хаягаар ирүүлэх боломжтой.

Тайлангийн хамрах хүрээ

Энэхүү тайланд тогтвортой байдлын тайлагналын удирдамж, НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилгууд болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын (IFRS) нэг хэсэг болох Sustainability Accounting Standards Board (SASB)-оос гаргасан даатгалын салбарын удирдамжийг ашигласан болно. SASB, БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж, НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилгуудад нийцүүлсэн дэлгэрэнгүй тодруулгыг хавсралтаас үзнэ үү.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтвортой хөгжлийн бодлого стратеги
БОНЗ-ын тогтолцоо
Бидний оролцоо



Тогтвортой хөгжлийн бодлого стратеги

Бид үйл ажиллагаандаа сайн засаглалыг хэрэгжүүлж, ил тод, ёс зүйтэй, нийгмийн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй бизнесийн бодлогыг баримтлан ажиллахыг эрмэлзэж, компанийн удирдлагын түвшинд тогтвортой хөгжлийн амлалтыг баталсан.

Энэхүү амлалт, бодлогыг хэрэгжүүлж ажилласнаар ажилтнууд, харилцагч нар, хөрөнгө оруулагч нар, түнш байгууллагууд, нийгэмд урт хугацааны үнэ цэнийг бий болгох, тэдний өмнө хүлээх үүрэг хариуцлага гэж ойлгож байна.

Бидний үйл ажиллагааны зарчим нь CIRCLE буюу ХҮРД гэсэн утгатай дараах бүтэцтэй.

C**Customer**

Даатгуулагчаа цаг
ямагт хүндэтгэсэн

I**Integrity**

Итгэл хүлээж, ёс
зүйг баримталсан

R**Respon-
sibility**

Хариуцлагатай
даатгалын
үйлчилгээг санал
болгосон

C**Collaboration**

Эрсдэлийн удирдлагын
зохистой бодлогыг хамтран
боловсруулан, болзошгүй
эрсдэлээс ямагт урьдчилан
сэргийлдэг

L**Long-term
perspective**

Урт хугацааны
түншлэлийн харилцааг
эрхэмлэж, оролцогч
талуудыг амжилтад
хөтөлсөн

E**Excellence
in service**

Мэргэжлийн түвшний
даатгалын хамгаалалт,
үйлчилгээг
даатгуулагчдаа санал
болгосон

Байгаль орчин, нийгэм, засаглалын амлалт

БАЙГАЛЬ ОРЧИН

- Байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулна.
- Ногоон даатгалын үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- Ногоон санаачилгыг дэмжинэ.
- Ногоон бонд, байгаль орчинд ээлтэй технологи бүхий бизнест хөрөнгө оруулалт хийнэ.
- Эрчим хүчний хэмнэлттэй шийдэл гаргана.
- Дижитал технологи, цахим даатгалын үйлчилгээг нэвтрүүлэх замаар байгаль орчны хариуцлагатай хэрэглээг дэмжинэ.



НИЙГЭМ

- Ажилтны эрх тэгш байдал, аюулгүй орчныг бий болгоно.
- Жендерийн тэгш байдлыг хангана.
- Харилцагчийн эрх ашгийг хамгаална.
- Аливаа асуудлаар ялгаварлан гадуурхах явдлыг зогсооно.
- Сайн дурын үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийг дэмжинэ.
- Залуу үеийг бэлдэж, оюутан залуусыг хамарсан боловсролыг дэмжих, нийгмийн хариуцлагын ажлуудыг зохион байгуулна.



ЗАСАГЛАЛ


- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг ханган олон нийтэд мэдээлнэ.
- Ёс зүйтэй шударга шийдвэр гаргана.
- Ижил тэгш хандлагыг баримтална.
- Ил тод байдлыг хангана.
- Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
- Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.
- Ашиг сонирхлын зөрчилгүй байдлыг чанд баримтална.



Тогтвортой хөгжил ба бидний оролцоо

Байгаль орчны хүрээнд

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хотын инженерийн байгууламжийн хэлтсээс зохион байгуулсан “Үер усны эрсдэлээс сэргийлэх” сэдэвт сургалтад компанийн даатгалын менежерүүд болон эрсдэл, нөхөн төлбөрийн газрын ажилтнууд хамрагдсан.



- Даатгуулагчийн цаг хугацаа, орон зайнаас үл хамаарсан онлайн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг “Ard” аппликейшнээр үзүүлж байгаа бөгөөд 2024 онд нөхөн төлбөрийн үйлчилгээ болон даатгалын гэрээ цуцлалт, хураамжийн буцаалтын үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. Ингэснээр цаасны хэрэглээг бууруулж хүрээлэн буй орчны экологийн тэнцвэрт байдлыг хангахад тодорхой хувь нэмэр оруулж ажилласан байна.

Тогтвортой хөгжил ба бидний оролцоо

- Үндэсний давхар даатгал ХК -ийн 10 жилийн ойд зориулсан “Эрсдэлд тэсвэртэй Монгол Улс” олон улсын форумын хэлэлцүүлэгт панелистаар оролцож даатгагчийн баталгааны талаар оролцогчдод мэдээлэл өглөө. Арга хэмжээнд ОУ-ын болон Монгол Улсын даатгалын салбарын төлөөлөгчид, Mongolian Re, Scor Re, Hanoi Re, AM Best, Gallagher, Seoul Guarantee Insurance, Huatai Insurance Agency, Belarus Re компанийн төлөөлөл оролцсон.



- “ЖАЙКА” Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ” танилцуулга, сургалтад Ард даатгал ХК-ийн даатгалын газар болон нөхөн төлбөрийн газрын ажилтнууд хамрагдсан.

Тогтвортой хөгжил ба бидний оролцоо

Нийгмийн хүрээнд

- Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран “Тогтвортой хөгжил болон БОНЗ-ын тайлагнал” сэдэвт сургалтыг компанийн ажилтнуудын дунд зохион байгуулж 40 ажилтан хамрагдсан.
- Ард даатгал ХК даатгалын салбарт анх удаа “Тогтвортой хөгжлийн тайлан 2023” тайланг гаргаж, олон нийтэд танилцуулсан. Тус тайланг Монголын Даатгалын холбоо, Монголын даатгалын зах зээлийн холбоо, Албан журмын даатгагчдын холбоо, Үндэсний давхар даатгал ХК, Санхүүгийн зохицуулах хорооны засаглал хариуцсан албан тушаалтан болон Auscham, Amcham, НҮБ, МҮХАҮТ-д тус тус хүргүүлэн уриалга гаргасан.



- СЗХ-ны даатгалын газрын ажилтнуудад “Тогтвортой хөгжлийн тайлан 2023”-ийг танилцуулж, тогтвортой хөгжлийн зорилго, зорилтын талаар сургалт хамтран зохион байгуулсан.

Тогтвортой хөгжил ба бидний оролцоо

- Хавдрын шалтгаант эрсдэлийг бууруулахад даатгалын салбарын оролцоог хангах, орчны бохирдлоос үүдэлтэй хавдрын суурь шалтгааныг даатгалын гэрээний харилцаагаар бууруулах, төрийн зарим чиг үүргийг даатгалын тогтолцоогоор шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх зорилгоор Монголын Даатгалын Холбоо, Амар Даатгал ХХК, Нэйшнл Лайф Даатгал ХХК нартай “Жилийн хамгийн том 1 хувь нөлөөллийн аян”-ы хүрээнд “Хавдраас сэргийлэхэд даатгалын оролцоо” сэдэвт хурлыг зохион байгуулсан.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд “Манна” нялхсын асран хамгаалах төвийн хүүхдүүдэд Сар шинийн баяр болон Хүүхдийн баярыг тохиолдуулан хэрэгцээтэй зүйлсээр нь туслалцаа үзүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү ажлыг 2012 оноос жил бүр зохион байгуулж байна.



- Ард Даатгал ХК, Монгол Хьюндай эмнэлэгтэй хамтран “Ard Mend” эрүүл мэндийн өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр иргэд, байгууллагын ажилтнуудад мэс засал, мэдрэл, дотор, чих хамар, хоолойн анхан шатны үзлэг, оношилгоог хийж, эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээллийг үнэ төлбөргүйгээр өглөө. Өдөрлөгт нийт 100 орчим хүнийг хамруулсан.

Тогтвортой хөгжил ба бидний оролцоо

- Компани үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Дорнод салбар нь БОНЗ-ын хүрээнд хүүхэд хамгааллын хувьд даатгалын салбар ямар үүрэг хариуцлагатай ажилладаг тухай мөн эрсдэлт нөхцөл байдал тулгарсан үед авах арга хэмжээний заавар, зөвлөмжийг багш, эцэг эх, асран хамгаалагчдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав.



- Спорт, эрүүл мэндийг дэмжигч компанийн хувьд Монголын волейболын холбооны Үндэсний дээд лигийн Хасу Мегастарс багтай хамтын ажиллагааны гэрээг байгуулж, тус багийн тамирчдыг ивээн тэтгэн ажилласан төдийгүй тус баг нь 2024 онд аварга болсон билээ.

Тогтвортой хөгжил ба бидний оролцоо

- Монголын спорт аяллын холбоо /МСАХ/-ноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Оюутны Улсын Аварга Шалгаруулах “Алтан намар” тэмцээнийг өөрийн нэрэмжит болгон ивээн тэтгэж зохион байгууллаа. Тэмцээнд хот, хөдөөгийн 13 Их, дээд сургуулиудыг төлөөлж 21 баг оролцохоор мэдүүлгээ ирүүлснээс 19 багийн 200 гаруй оюутан оролцлоо.
- Уламжлал болгон зохион байгуулагддаг “Монголын Эдийн Засгийн Форум 2024”-ын “Улаанбаатар хотын Бүсчилсэн хөгжил” арга хэмжээний зохион байгуулалтын ажлыг Ард даатгал ХК амжилттай зохин байгуулахад хамтран ажиллаа.
- Ард санхүүгийн нэгдлээс 8 дахь удаагаа зохион байгуулсан “Хөрөнгө оруулагч үндэстэн 2024” чуулганд оролцож үндсэн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан хэлэлцүүлгүүдэд оролцож, Даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулгыг хүргэж ажилласан.



Тогтвортой хөгжил ба бидний оролцоо

Засаглалын хүрээнд

- “Жолоочийн даатгалын нийгэмд үзүүлэх нөлөө” сэдэвт хэлэлцүүлгийг Ард даатгал ХК-аас санаачлан зохион байгуулж, жолоочийн даатгалтай холбоотой үүсэж байгаа өнөөгийн асуудлууд, хуулийн өөрчлөлтөд санал тусгах, жолоочийн даатгалаар дамжуулж нийслэлийн замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах боломж бололцооны талаар хэлэлцсэн. Хэлэлцүүлэгт Ард даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга О.Одбаяр, УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц, Албан журмын даатгагчдын холбооны Гүйцэтгэх захирал М.Өлзийбат, Монголын даатгалын Холбооны Гүйцэтгэх захирал Ж.Батжаргал нар оролцсон байна.



- Монгол Улсын Засгийн Газар, Эрдэс баялгийн яам, Уул уурхайн ассоциаци, Уул уурхайн салбар болон Хөрөнгө оруулагчдын төлөөллийн оролцоотой “Уул уурхайн үзэсгэлэн, чуулган 2024” арга хэмжээнд даатгалын салбарыг төлөөлөн “Эрдэс баялгийн салбар болон даатгалын салбарын уялдаа” сэдвээр илтгэлийг танилцуулсан.





ДААТГАЛ
SINCE 1994

БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчны эрсдэл
Байгалийн гамшгийн хамгаалалт
Цахим даатгал

Уур амьсгалын эрсдэлүүд

Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, хүлэмжийн хийн ялгаралтай холбоотой уур амьсгалын өөрчлөлт ихсэж байгаа нь олон нийтийн өмнө тулгамдаж буй асуудал хэвээр байсаар байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан байгалийн гамшгийн давтамж нэмэгдэж буй үед дараах эрсдэлүүдээс даатгаж харилцагчдаа гэнэтийн санхүүгийн эрсдэлээс хамгаалж байна. Эдгээр эрсдэлүүдэд даатгалын 9 төрлийн, 24 бүтээгдэхүүнийг харилцагч нартаа санал болгож байна.

Даатгалаар хамгаалагдаж буй уур амьсгалын эрсдэлүүд

Байгалийн эрсдэл

- Хүчит салхи;
- Цасан болон шороон шуурга;
- Ган, зуд, цочир хүйтрэлт;
- Үер;
- Газар хөдлөлт, хөрс, чулууны нуралт, овойлт, цөмрөлт, хөрсний усны түвшин;
- Хүйтэн бороо, аянга, мөндөр, хяруу;
- Ой хээрийн түймэр, шаварт унаж шигдэх, хөлдөх, осгох, наранд цохиулах зэрэг эрсдэл.

Галын эрсдэл

- Гал, түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт



Эрүүл мэнд,
гэнэтийн ослын
даатгал



Хөрөнгийн
даатгал



Авто
тээврийн
хэрэгслийн
даатгал



Ачаа
тээврийн
даатгал



Барилга
угсралтын
даатгал



Малын
индексжүүлсэн
даатгал



Газар
тариалангийн
даатгал



Бизнесийн
тасалдлын
даатгал




Түрээслэгчийн
хариуцлагын
даатгал



Байгалийн гамшгийн хамгаалалт

2024 онд байгалийн эрсдэлүүд буюу гал түймэр, үер усны аюул болон шороон шуурганаас үүдэлтэй хохиролд хөрөнгийн даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, гэнэтийн ослын даатгалаар **538 сая төгрөгийн** нөхөн төлбөрийг төлсөн байна.



Малын индексжүүлсэн даатгал

Монгол улсын уламжлалт мал аж ахуйн салбарт тохиолддог байгаль, цаг уурын эрс тэс нөхцөл болон гэнэтийн гамшгаас үүдэлтэй ихээхэн хэмжээний хохирлоос урьдчилан сэргийлж малчдын амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг хамгаалах зорилготой “Малын индексжүүлсэн даатгал”-ыг (МИД) Үндэсний давхар даатгал ХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

2024 онд

254.5 сая ₮

Хураамжийн орлого

696.8 сая ₮

Нөхөн төлбөр



МИД-ын хүрээнд доор дурдсан хохирлоос үүдэн гарах хорогдлыг нөхөн олгодог.


- Зуд;
- Өвчин эмгэг;
- Чоно, нохойд баригдах;
- Хулгайд алдах.

Байгаль орчноо хамгаалах бидний хариуцлага

Цахим даатгал

Цаасны хэрэглээг багасгах, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилгоор даатгалын үндсэн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж байна.

Ard аппликейшнээр дамжуулан доорх даатгалын үйлчилгээг цахимаар үзүүлж байна.



Цахим нөхөн төлбөр

Даатгалын нөхөн төлбөрийн үйлчилгээг хялбар, түргэн шуурхай, харилцагчид чирэгдэлгүй үзүүлэх үүднээс доорх даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт, холбогдох материалыг цахимаар авч байна. Үүнд:

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
- Тээврийн хэрэгслийн даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Гадаадад болон дотоод аяллын даатгал
- Зээлдэгчийн барьцаа хөрөнгө
- Гадаадад болон дотоод аяллын даатгал
- Орон сууц эзэмшигчдийн даатгал
- Гадаад ачаа тээврийн даатгал зэрэг бүтээгдэхүүнүүдийн нөхөн төлбөрийн материалыг цахимаар авч байна.



Мөн hiрау, toki, “Авто тээврийн үндэсний төв”-ийн Autobox зэрэг аппликейшнтэй хамтран харилцагчийн цагийг хэмнэх, түргэн шуурхай даатгалын үйлчилгээ авах боломжийг олгож эхэлсэн. Цахим даатгал, цахим нөхөн төлбөрийн үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр 2024 оны цаасны хэрэглээ өнгөрсөн жилээс буурсан ба мөн принтерийн хор, архивын үйл ажиллагаа, цаас устгалаас бий болох агаарын бохирдлыг бууруулах зэрэг эерэг нөлөөллүүд гарсан байна.



ДААТГАЛ
SINCE 1994

НИЙГЭМ

ХАРИУЦЛАГАТАЙ

Даатгагч
Ажил олгогч
Хувьцаат компани
Хамтын ажиллагаа



Даатгалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт

2024 оны байдлаар бидний санал болгож буй 41 гаруй даатгалын бүтээгдэхүүнээс **гэнэтийн осол, эмчилгээний даатгал** нь тогтвортой хөгжлийн зорилгын эрүүл мэндийг дэмжих, ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих гэсэн 3, 11-р зорилгуудад хувь нэмэр оруулж байна. Энэ төрлийн даатгалд дараах бүтээгдэхүүнүүд хамаардаг.



Ард-мэнд
дотоодын
эрүүл мэнд



Ард-мед
олон улсын
эрүүл мэнд



Ард-мэнд
гэнэтийн
ослын даатгал



Авто машины
суудлын
гэнэтийн
ослын даатгал



Гадаад
зорчигчийн
даатгал



Хүүхдийн
гэнэтийн
ослын даатгал



Иргэдийн
гэнэтийн
ослын даатгал



Хөдөлмөрийн
чадвар түр
алдалт

Манай харилцагчид БНХАУ, Солонгос, Япон, Тайланд, Монгол, Австрали, Герман, Швед, Швейцарь зэрэг улсуудын сүлжээ эмнэлгүүдээр үйлчлүүлж эрүүл мэндийн даатгалаар шууд төлбөрийн үйлчилгээг авсан байна. **2024 онд эрүүл мэнд болон гэнэтийн ослын даатгалаар олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг доор харуулав.**

2,200 орчим нэхэмжлэлд

2.4 тэрбум төгрөг

нөхөн төлбөрийг олгов.

Манай компани иргэдийн эрүүл мэндийн даатгалын боловсролд илүү анхаарч ажилладаг бөгөөд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл, сургалтуудыг мэргэжлийн эмч нартай хамтран зохион байгууллаа.

150 байгууллагын

3,000 гаруй ажилтан

сүлжэлтэд хамрагдав.


Даатгалын андеррайтинг

Сэргээгдэх эрчим хүч

Бид байгаль дэлхийд ээлтэй, хар салхи гэх мэт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр үүсвэрийг бийг болгож байгаа, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөнгөлөлттэй хураамжаар даатгаж байна.

2024 оны байдлаар даатгалын нийт хураамжийн 2.2% буюу 1 тэрбум төгрөгийг сэргээгдэх эрчим хүч, ногоон үйл ажиллагаа явуулдаг компанийн даатгалын хураамж эзэлж байна.

Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 компанийн байгаль орчинд үзүүлсэн нөлөөллийг дор үзүүлэв.



Бизнес эрхлэгчдэд

Ард даатгал ХК нь үйлдвэрлэл, худалдаа, уул уурхай, барилга, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд, групп компаниудтай урт хугацааны бизнесийн харилцааг үүсгэж хамтран ажиллаж байгаа бөгөөд тухай бизнесийн онцлогт тохирсон эрсдэлүүдийг удирдах чиглэлээр зөвлөгөө, сургалтыг өгч даатгалын үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

2024 онд байгууллагын даатгалаар олгосон нөхөн төлбөрийн хохирлын харьцааг даатгалын төрлөөр харуулав.

**76%**

Жолоочийн
хариуцлагын
албан журмын
даатгал

31%

Авто тээврийн
хэрэгсэл

6%

Хариуцлагын
даатгал

5%

Хөрөнгийн
даатгал

65%

Гэнэтийн осол,
эмчилгээний
даатгал

Даатгалын нөхөн төлбөр

Манай компани нь нийгмийн амар тайван байдал, хүний эрхийн эсрэг чиглэсэн аливаа үйл ажиллагаа, тохиолдлуудыг хөхүүлэн дэмжихгүй байхад анхааран ажилладаг бөгөөд үүнтэй холбоотойгоор даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах заалтыг даатгалын гэрээнд тусгасан байдаг. Жишээг дурдвал:

- Байлдааны зэвсэг хэрэглэх, атомын, цөмийн болон цацраг идэвхт эрсдэлүүдээс үүссэн хохирол
- Ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага
- Дайн, хувьсгал, маргаан булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, тэсрэх бөмбөг дэлбэрэх, террорист
- Улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол
- Гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол

Тээврийн хэрэгсэлтэй холбоотой даатгалын хохирол баталгаажуулалтыг түргэн шуурхай, тодорхой болгосноор нөхөн төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

50%

Ард даатгал ХК-ийн хохирол
баталгаажуулалт

50%

Тээврийн Цагдаагийн
Албаны хохирол
баталгаажуулалт

2024 онд тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр нийт 13.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 10,252 тохиолдолд олгосон байна.

Нөөц сангийн хөрөнгө оруулалт

Өмнөх жилүүдэд даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтын багцын дийлэнх хувийг банк, санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн эзэлж байсан бол 2024 онд удирдлагын амлалт, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг сөрөг нөлөөгүй, ногоон бонд, ногоон эдийн засгийг дэмжсэн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.

2024 оны хөрөнгө оруулалтын багцыг өмнөх жилтэй харьцуулж харуулбал:

2023 он



2024 он




Тасралтгүй хөгжил, тогтвортой ажлын байр

Байгууллагын үнэт зүйл бол манай ажилтнууд байдаг. Ард Даатгал компанийн ажилтнуудын дийлэнх хэсгийг 5-35 жилийн даатгалын салбарын ажлын туршлагатай баг, хамт олон эзэлдэг. Байгууллагын зүгээс ажлын уян хатан цаг, ажлын байрны хүртээмжтэй байдлыг хангахын зэрэгцээ тэдний мэдлэг, боловсролын өсөлт, хөгжлийг дэмжих, өрсөлдөхүйц цалин, урамшуулал олгоход ямагт анхаардаг.

Хүний нөөцийн тогтвортой байдал **88,4%**

Хүний нөөцийн эргэц **9.5%**



Нийт үндсэн ажилчид

66%

34%

Гүйцэтгэх удирдлага

25%

75%

Дунд болон анхан шатны нэгж

44%

56%

2024 онд байгууллагын ажилтнууд
нийт 240 цагийн

сургалтад хамрагдав.

Мэргэжлийн ур чадвар

Хувь хүний хөгжил

Байгууллагын соёл

Байгууллагын зүгээс ажилтнуудын санхүүгийн байдлыг дэмжихэд анхааран дараах тэтгэмж, урамшууллыг олгож байна. Мөн 2023 оноос цалинтай дадлагажигч хөтөлбөр буюу оюутан, залуусыг Ард даатгал ХК-д цалинтай дадлага хийх боломжийг олгож эхэлсэн.



Хувьцааны урамшуулал



Тэтгэврийн хуримтлал



Ард койны урамшуулал




Эрүүл мэндийн даатгал



Гэнэтийн ослын даатгал

Үнэ цэнтэй хөрөнгө оруулалт

Ард даатгал ХК нь 2018 онд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болсноос хойш хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын үнэ цэнийг бий болгохоор ажиллаж байна. Компанийн тогтвортой ногдол ашгийн бодлогын хүрээнд 2018 оноос хойш хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн болон бусад хэлбэрийн ногдол ашиг олгож ирсэн.



ИТГЭМЖИТ ТҮНШ

Бид бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа хамтын ажиллагааг эрхэмлэж, дотоод гадаадын хувь хүн болон байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Яам гэх мэт бүхий л салбаруудад хүрч ажиллажээ. Тухайлбал:

- Агаарын тээвэр
- Барилга угсралт
- Үл хөдлөх хөрөнгө
- Дэд бүтэц,
- Эрчим хүч
- Уул уурхай газрын тос
- Хөдөө аж ахуй
- Зам тээвэр
- Худалдаа үйлчилгээ
- Хөнгөн ба хүнд үйлдвэрлэл
- Батлан хамгаалах
- Иргэний нисэх
- Олон нийтийн байгууллагууд
- Эрдэм шинжилгээ
- Боловсрол
- Хууль эрхзүй
- Олон улсын байгууллага
- Банк санхүү
- Аялал жуулчлал
- Эрүүл мэнд
- Мэдээлэл технологи
- Харилцаа холбоо
- Төрийн ба төрийн бус
- Элчин сайдын яам

Бид цаашид тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоод болон гадаадын байгууллагуудтай хамтран ажиллаж, байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудаа илүү боловсронгуй болгохоор төлөвлөж байна.

+220

Төрийн
байгууллагууд

70%

МҮХАҮТ-аас
эрэмбэлдэг
ТОП-100
компани

+70

Даатгалын
зуучлагчид
болон
байгууллага

+20

Давхар
даатгалын
компани

+330k

Эрүүл мэндийн
даатгалын гэрээт
сүлжээ
эмнэлгүүд

LLOYDS

UIB

Hannover Re

Swiss Re

helvetia

Gallagher Re

Allianz

Munich RE

AON

hannover re

Miller

Marnix

MSH

TOKIO MARINE

JILBODA

Willis

COVERHIL

ZURICH

Kuwait Re

Marsh



ДААТГАЛ
SINCE 1994

ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал
Ёс зүй ба комплайнс
Эрсдэлийн удирдлага
Мэдээллийн аюулгүй байдал

Компанийн засаглалын хүрээнд хяналт, хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэхээс гадна байгууллагын үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулахад чиглэдэг. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь салбартаа мэргэшсэн, оновчтой шийдвэр гаргалт, удирдлагын манлайллаар хангахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах, урт хугацааны өгөөжийг бий болгоход дэмжин ажилладаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөл	9 гишүүнтэй ба үүнээс 33%-ийг хараат бус гишүүд эзэлдэг. - Нийт гишүүдийн 33.3%-ийг эмэгтэй гишүүд эзэлдэг.
Гүйцэтгэх Удирдлага	- Компанийн хэрэгжүүлж буй тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг шууд удирдлагаар хангана. - Тогтвортой хөгжлийн тайлан бэлтгэх, мэдээллийн урсгалыг удирдана.
Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо	- Тогтвортой байдал, засаглалын асуудалтай холбоотой асуудлуудыг Удирдах зөвлөлд тайлагнана. - Тогтвортой хөгжлийн чиглэлээр санал, санаачилга гаргаж буй ажилтнуудыг урамшуулах бодлого тодорхойлно.
Санхүү, Эрсдэл, Хөрөнгө оруулалтын хороо	- Даатгалын андеррайтинг, нөхөн төлбөр, бүтээгдэхүүн хөгжүүлэлт зэрэг үндсэн үйл ажиллагааны хүрээнд тогтвортой хөгжил болон байгаль орчин, нийгэмд эергээр нөлөөлөх ажлуудыг зохион байгуулна. 2025 он гэхэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, эрсдэлийн үнэлгээний аргачлалд БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийг бүрэн тусгахаар ажиллаж байна. - Компанийн нягтлан бодох бүртгэл болон бүхий л үйл ажиллагааны тайлагналын үнэн зөв байдал холбогдох хууль, дүрэмд нийцтэй байгаа зэрэгт хяналт тавьж, ТУЗ-ийг хяналтын үүргээ биелүүлэх нөхцөлөөр хангаж ажилладаг. - Тогтвортой хөгжлийн тайланд тусгагдсан тоо мэдээлэл, өгөгдлийн үнэн, зөв, найдвартай байдалд хяналт тавьна.

Ёс зүйн дүрэм

Бид албан үүрэг гүйцэтгэхдээ хуулийг чандлан дээдлэхийн зэрэгцээ Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан байгууллагын "Ёс зүйн дүрэм"-д тусгагдсан дараах хэм хэмжээг баримтлан ажилладаг.



Авлигын эсрэг бодлого

Авлигын шинж чанартай аливаа үйлдлээс ангид байхыг өдөр тутмын үйл ажиллагаандаа анхааран ажилладаг бөгөөд дараах үйлдлүүдийг хориглодог.

- Албан тушаалын давуу байдлаа ашиглах, бусдад давуу байдал олгох, өөрт шан харамж авах, бусдыг дарамтлах, гүтгэх;
- Хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал, боломжоо ашиглах, хэн нэгэнд хууль бус шаардлага тулгах;
- Хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, албан бичиг баримтыг хуурамчаар хэрэглэх, хууль бусаар үйлдэх;
- Удирдах ажилтан нь бүх ажилтанд шударга, эрх тэгш хандах зарчим баримтлах бөгөөд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, хэт дөвийлгөн сайшаах, онцгой анхаарал хандуулах, эсвэл дорд үзэх;

Комплайнсын бодлого

Манай байгууллага нь 2024 оны туршид Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон зохицуулах байгууллагуудын шаардлагад нийцүүлэн комплайнсын тогтолцоог бэхжүүлэх, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах зорилт тавин ажиллалаа. Мөн хууль эрх зүйн орчинд нийцсэн, ил тод, хариуцлагатай үйл ажиллагаа явуулахыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байгаа бөгөөд комплайнсын тогтолцоог тасралтгүй сайжруулж, олон улсын шилдэг туршлагыг нутагшуулахыг эрмэлзэж байна.



Энэхүү зорилтын хүрээнд дараах гол ажлуудыг амжилттай хэрэгжүүлэв:

Дотоод хяналтын хөтөлбөрийн шинэчлэл:

- Монгол Улсын хууль тогтоомж болон зохицуулах байгууллагуудын зүгээс мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд тавьж буй шинэчлэгдсэн шаардлагыг тусган, Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн тухай хуулийн хүрээнд дотоод хяналтын хөтөлбөрийг дахин боловсруулж, шинэчлэн баталлаа.

Комплайнсын хөтөлбөрийн боловсруулалт:

- Байгууллагын хэмжээнд үйл ажиллагааны эрх зүйн нийцлийг хангах, эрсдэлийг бууруулах зорилго бүхий комплайнсын хөтөлбөрийг шинээр боловсруулан баталж, хэрэгжүүлж эхлээд байна.

Харилцагчийг таньж мэдэх асуулгын хуудасны шинэчлэл:

- Харилцагчийн мэдээллийг үнэн зөв, бүрэн аван эрсдэлийг үнэлэх зорилгоор харилцагчийг таньж мэдэх асуулгын хуудсыг олон улсын чиг хандлага, үндэсний шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталгаажууллаа.

Хэрэгжилтийг хангах төлөвлөгөө, хяналт:

- Дээрх хөтөлбөр, журам, аргачлалуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор шат дараатай төлөвлөгөө гарган, холбогдох нэгжүүдэд чиглэл өгч, хэрэгжилтийг хянан тайлагнах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Эрсдэлд суурилсан шийдвэр гаргалт

Манай компани нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг болон даатгуулагчийн өмнө хүлээсэн хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын оновчтой бодлогыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Эрсдэлийг эрт илрүүлэх, ангилж үнэлэх, бууруулах;
- Боломжит эрсдэлийг хүлээн авах;
- Эрсдэлд суурилсан хөрөнгийн үнэлгээ тооцох;
- Төлбөрийн чадварын үнэлгээ хийх;
- Хохиролд суурилсан эрсдэлийн шинжилгээ хийх.

Мөн бид даатгуулагчид, харилцагчдын даатгалын зүйлийн эрсдэлийн үнэлгээг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран эрсдэлийг бууруулах заавар зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллаж байна.

